## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН
### /2022 оны жилийн эцсийн тайлан/

Эрүүл мэндийн газар 2022.12.06

| № | Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг | Төсөв /сая төгрөг/ | | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан нөхцөл тайлбар) | Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь | Тайлбар (Хүрээгүй бол шалтгаан нөхцөлийн тайлбар) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөсөн | Гүйцэтгэл | | Он | Түвшин | Он | Түвшин | | | |
| **Эрүүл мэнд** | | | | | | | | | | | |
| **2.2. Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, эмнэлгийн мэргэжилтний хангалтыг сайжруулж, чадавхыг дээшлүүлнэ** | | | | | | | | | | | |
| 14 | 2.2.1. Эрүүл мэндийг дэмжих төвийг байгуулж, халдварт болон халдварт бус өвчнийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ | 14.0 | 6.4 | Эрүүл мэндийг дэмжих төвийг байгуулах<br><br>Хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь<br><br>Вируст гепатитын өвчлөл<br><br>Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь<br><br>Сүрьеэ өвчлөлийн түвшин<br><br>Тэмбүү өвчний түвшин | 2021 | ЭМДТ байгуулсан байна<br><br>76.7<br><br>0.0<br><br>34.5<br><br>8.4 ихгүй | 2022 | Эрүүл мэндийг дэмжих төвийг байгуулана<br><br>77.2<br><br>0.0<br><br>38.0<br><br>8.0<br><br>16.0 | Эрүүл мэндийн яамны 432 сая төгрөгийн санхүүжилтээр Өгөөмөрдэнж ХХК нь эрүүл мэндийг дэмжих төвийн их засварыг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Эрүүл мэндийг дэмжих төвд УТХОруулалтаар 1.4 тэр бум төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн байна.<br>2022 оны 05 сарын 2-ны өдөр Эрүүл мэндийг дэмжих төвийн нээлтийн үйл ажиллагааг хийж “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг, оншилгоо, шинжилгээг хийж байна.<br>Хорт хавдарын эрт илрүүлгийн хамралт 61.0 хувьтай байна. Үүнд:<br>● Хөхний хорт хавдрын эрт илүүлэг үзлэг шинжилгээнд 30-60 насны 3458 эмэгтэйчүүд хамрагдахаас 3458 эмэгтэй хамрагдаж 100.0 хувьтай,<br>● Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 1241 эмэгтэй хамрагдахаас 331 эмэгтэй хамрагдаж 26.6 хувьтай | 70.5 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 16.0<br>ихгүй | | | ● Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 4429 иргэн хамрагдахаас 2500 иргэн хамрагдаж 56.4 хувьтай байна<br>**2022 оны 11 сарын байдлаар:**<br>- Вируст гепатитын 4 тохиолдол бүртгэгдэж вируст гепатитын өвчлөлийн түвшин 2.2 байна.<br>- Нийт үзлэг 122497 байна. Үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 24651 буюу 20.0 хувийг эзэлж байна.<br>- Сүрьеэ өвчний 12 тохиолдол бүртгэгдэн 10000 хүн амд 6.6 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцулахад ижил түвшинд байна. Мөн аймгийн дундажтай ижил түвшинд байна.<br>-Тэмбүү өвчний 13 тохиолдол бүртгэгдэн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12 тохиолдлоор өсч 10000 хүн амд 7.1 буюу улс, аймгийн дунджаас доогуур үзүүлэлттэй байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Эрүүл мэндийн яамны санхүүжилтээр 432 сая төгрөгийн их засвар, УТХО-аар 1.4 тэр бум төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдэн Эрүүл мэндийг дэмжих төвийг байгуулсан.<br>Хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь 61.0<br>Урьдчилан сэргийлэх үзлэг 20.0 хувь<br>Вируст гепатитын өвчлөлийн түвшин 2.2<br>Сүрьеэ өвчлөлийн түвшин 6.6<br>Тэмбүү өвчний түвшин 7.1 | | |
| 15 | 2.2.2. Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, иргэдийн | 26 | 24.4 | Хүн амын дундаж наслалт<br><br>Мэдээлэл хүртсэн иргэдийн тоо | 2021 | 73.6<br><br>10000 | 2022 | 73.7<br><br>15000 /давхардсан тоогоор/ | Төрөлтөөс тооцсон хүн амын дундаж наслалтыг 2021 онд манай аймагт 73.56 байгаа бол улсын хэмжээнд 70.71 байна.<br>Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, эрт илрүүлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах талаар 68 төрлийн постерийг | 89.6 | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, нас баралтын түвшинг бууруулна | | | Эрт илрүүлэг үзлэгийн дундаж<br><br>Артерийн даралт ихсэн өвчний эрт илрүүлэг<br><br>Чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралт<br><br>Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин<br><br>Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин | | /давхар дсан тоогоор/<br><br>87.0<br><br>100<br><br>100<br><br>11.8<br><br>12.7 | | 87.0<br><br>100<br><br>100<br><br>11.6<br><br>12.5 | Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын цахим хаягуудад байршуулж мэдээлэл өгч ажилласан. Нийт 15600 хүний хандалт авч, 4150 хүн тухайн мэдээлийг хуваалцаж, 2400 хүнд таалагдсан байна.<br>Эрт илрүүлэг үзлэгийн дундаж 70.1 хувь<br>● Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэгт 18-с дээш насны 10991 иргэн хамрагдахаас 8578 иргэн хамрагдаж 78.0 хувьтай, шинээр артерийн даралт ихсэлттэй 79 хүнийг оношилж хяналтад авсан.<br>● Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 35-с дээш насны 6400 иргэн хамрагдахаас 5749 иргэн хамрагдаж 89.8 хувьтай байна. Шинээр чихрийн шижинтэй 2 хүнийг оношилж хяналтад авсан.<br>Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын 20 тохиолдол бүртгэгдэж өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин 11.0 буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 тохиолдолоор буурсан үзүүлэлттэй байна.<br>Хорт хавдарын өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын 20 тохиолдол бүртгэгдэж хорт хавдараас шалтгаалсан нас баралтын түвшин 10 000 хүн амд 11.0 байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хүн амын дундаж наслалт 73.56<br>Цахимд оруулсан мэдээллийн тоо 68, хандалт авсан хүний тоо 15600, тухайн мэдээлэл таалагдсан хүний тоо 2400<br>Эрт илрүүлгийн дундаж 70.1 хувь<br>Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэгт хамрагдалт 78.0 хувь | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдалт 89.8 хувь<br>Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин 10 000 хүн амд 11.0<br>Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин 10 000 хүн амд 11.0 | | |
| 16 | 2.2.3. Оношилгоо, эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт технологийг нутагшуулна | - | 3 сая | Шинээр нэвтрүүлсэн тусламж үйлчилгээний тоо | 2021 | 1 | 2022 | Эрэгтэйчүүд судлал, гэмтэл, дотоод шүүрлийн эмчилгээг хийж эхэлнэ. | Аймгийн нэгдсэн эмнэлэгт 2021 оноос бөөр судлалаар мэргэшсэн их эмч орон тоогоор ажиллаж иргэд, үйлчлүүлэгчдэд эрэгтэйчүүд, бөөр, шээсний замын эмгэгийн тусламж үйлчилгээг үзүүлж эхэлсэн. 2022 онд УНТЭ-т андрологи /эрэгтэйчүүд судлал/ чиглэлээр төрөлжсөн мэргэшил эзэмшихээр суралцаж байна.<br>Мөн 2021 оноос гэмтэл, согог судлалын нарийн мэргэжлийн эмч ажиллаж, улмаар мэргэшүүлэх сургалтад хамрагдаж ирээд үений гэмтлийн тусламж үйлчилгээг үзүүлж эхлээд байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Андрологи /эрэгтэйчүүд судлал/ чиглэлээр нэг их эмч суралцаж байна.<br>Гэмтлийн нарийн мэргэжлийн эмч тусламж үйлчилгээ үзүүлж байна. | 100.0 | |
| 17 | 2.2.4. Яаралтай тусламж үйлчилгээний хүртээмж чадавхыг сайжруулж, парк шинэчлэлийг хийнэ | 30 | 730 сая | Автомашины тоо<br><br>Тоног төхөөрөмжийн тоо | 2021 | 1<br><br>3 | 2022 | Аймгийн Нэгдсэн эмнэлгийг яаралтай тусламжийн тоног төхөөрөмж өөр хангана. | 2022 оны 3 сард зохион байгуулагдсан Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөний үеэр аймгуудын нэгдсэн эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээнд 155,0 сая төгрөгийн ланд-78 загварын автомашиныг хүлээлгэн өгөхөөр батламж гардуулсан. Одоогоор хүлээн аваагүй байна.<br>Улсын төсвөөс Өрхийн эрүүл мэндийн төвийн яаралтай үед үзүүлэх тусламж үйлчилгээнд шаардлагатай тоног | 90.0 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | төхөөрөмж болох Хүчилтөрөгч аппарат-1, хяналтын монитор-1, яаралтай тусламжийн иж бүрдэл цүнх-2 нийт 3,8 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангаад байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламж үйлчилгээний чадавхи сайжирч байна. | | |
| 18 | 2.2.5. Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн, оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг нэвтрүүлнэ | 68.2 | 68.2 | Алсын зайн технологи нэвтэрсэн ЭМБ-ын тоо; | 2021 | 2 | 2022 | Сүмбэр сумын Өрхийн эрүүл мэндийн төвд Мобайл технологи нэвтрүүлнэ. | ДЭМБ-ийн хөрөнгө оруулалтаар Шивээговь сумын эрүүл мэндийн төвд 2018 онд, Баянтал, Сүмбэр сумын өрхийн эрүүл мэндийн төвд 2021 онд Мобайл технологийн тоног төхөөрөмжөөр хангаж, алслагдсан баг, өрхийн хүн амд тусламж үйлчилгээг үзүүлж байна.<br>Эхний 9 сарын байдлаар: Өрхийн эрүүл мэндийн төвөөс "ЭРҮҮЛ ЧИЙРЭГ ЭР ХҮН" аяны хүрээнд Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын газрын нийт 341 /давхардсан тоогоор/ алба хаагч, хөдөөгийн 3 багийн өдөрлөгийн үеэр 89 иргэнд тусламж үзүүлсэн. Шивээговь сумын эрүүл мэндийн төвд 48, Баянтал сумын эрүүл мэндийн төв амбулаториор үйлчлүүлсэн 8 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан байна.<br>Мобайл технологийн түргэвчилсэн оношлуураар нийт 4452 иргэнд шинжилгээ хийсэн. Үүнийг задалж авч үзвэл:<br>• HIV – 1346 иргэн<br>• ТРНА – 1744 иргэн /182 иргэн эерэг/<br>• Хелекобактер -192 иргэн<br>• В вирус – 681 иргэн /17 иргэн эерэг/ | 100.0 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | • С вирус – 681 иргэн /11 иргэн эерэг/<br>• Сахар-192 /17 иргэн эерэг/<br>• Холестрин-192 иргэнд тус тус шинжилгээ хийсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Мобайл технологоор тусламж үйлчилгээ үзүүлсэн хүн амын тоо 4938 | | |
| 19 | 2.2.6. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангах хангамж хүртээмжийг нэмэгдүүлнэ | - | - | Нэвтрүүлсэн программ хангамжийн тоо<br><br>Эм зүйн алба байгуулсан ЭМБ-ын тоо | 2021 | 1<br><br>1 | 2022 | Эмийн чанар аюулгүй байдлын программ хангамжийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.<br><br>Эм зүйн албаны үйл ажиллагаа тогтмолжуулна | Эмийн чанар, аюулгүй байдлын программын чухал хэсэг болон Цахим жорын модулийг орон нутгийн түвшинд ашиглаж байна. Аймгийн хэмжээнд бүх шатлалын Эрүүл мэндийн байгууллагуудад цахим жор бичих эрх бүхий 37 эмч (Нэгдсэн эмнэлэгт 24, Шивээговь сумын эрүүл мэндийн төвд 2, Баянтал сумын эрүүл мэндийн төвд-2, “Энхтусдэм” Өрхийн эрүүл мэндийн төвд 6, Энхбилтиг клиникт 3) ажиллаж байна. 2022 оны эхний 9 сард 8 эмийн санд давхардсан тоогоор 10670 иргэн цахим жороор үйлчлүүлсэн. Тайлант хугацаанд цахим жорыг нэвтрүүлсэн эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагын тоо 2-оор нэмэгдэж, 13 болсон.<br>2022 оны 9 сарын байдлаар эрүүл мэндийн байгууллагуудад дунджаар Зайлшгүй шаардлагатай эмийн хангамж 80.3%, Амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн байх ёстой нөөцийг 2 сараар тооцоолон бүрдүүлэн ажиллаж байгаа ба 87.8%, Ковид-19 халдварын үеийн эм,эмнэлгийн хэрэгслийн нөөц 91.7%-тай буюу дунджаар 55 хоногийн нөөцтэй байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Эм зүйн албаны зохион байгуулалтын 70%-ийг хангасан. | 85.0 | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Эмийн чанар, аюулгүй байдлын программ хангамж бүрэн нэвтэрсэн. | | |
| 20 | 2.2.7. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулна | 15 | 11.5 | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь<br><br>Хүний нөөцийн хангалтын хувь<br><br>Ур чадвараа сайжруулсан эмчийн тоо | 2021 | 100.0<br><br>88.0<br><br>10 | 2022 | 100.0<br><br>88.0<br><br>12 | Эрүүл мэндийн ажилчдын Нийгмийн баталгааг хангах арга хэмжээг 4 зорилт 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ЭМГ-ын даргаар батлуулсан. 2022 оны 10 сарын байдлаар арга хэмжээний хэрэгжилт 93.3 хувьтай байна.<br>Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт 85.0 хувьтай байна.<br>Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтад Эрчимт эмчилгээ, Дүрс оношилгоо, Сэтгэц, Эх барих эмэгтэйчүүд, Яаралтай тусламж, Хүүхэд, Мэс засал чиглэлээр 7 их эмч, төрөлжсөн мэргэшлийн сургалтад Гемодиализын сувилагч, Гемодиализын техникч, Эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн ажилтан, Мэс заслын сувилахуй чиглэлээр 4 сувилагч тусгай мэргэжилтнийг хамруулсан.<br>Мэргэжил дээшлүүлэх сургалтад төрийн сангийн зардлаар эх барих, эмэгтэйчүүдийэн хэт авиан оношилгоо чиглэлээр 1 их эмч, Эрүүл мэндийг дэмжих арга хэмжээний зардлаар Гемодиализын их эмч 1 суралцаж байна.<br>Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв болон лавлагаа шатлалын ЭМБ-уудаас зохион байгуулсан цахим болон танхимын 48 удаагийн сургалт зөвлөгөөнд давхардсан тоогоор 172 албан хаагч хамрагдсан байна.<br>ЭМЯ, ЭМХТ болон лавлагаа шатлалын ЭМБ-уудаас зохион байгуулсан цахим болон танхимын 28 удаагийн сургалт зөвлөгөөнд давхардсан тоогоор 138 албан хаагч хамрагдсан байна.<br>**Хүрсэн түвшин:** | 92.7 | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг хангах арга хэмжээний хэрэгжилт 93.3 хувь,<br>Хүний нөөцийн хангалт 85.0 хувь,<br>Төгсөлтийн дараах үндсэн мэргэшил, төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулсан эмч, мэргэжилтний тоо-13 | | |
| 21 | 2.2.8. Эмнэлгийн хагас бие даасан байдлыг хангах бэлтгэл ажлыг бүрэн хийнэ | - | - | Сургалтын тоо<br><br>Сургалтад хамрагдсан ажилтны тоо<br><br>Төлөөлөн удирдах зөвлөл байгуулах ажлын гүйцэтгэл | 2021 | - | 2022 | Сургалтын тоо<br><br>Сургалтад хамрагдсан ажилтны тоо<br><br>Төлөөлөн удирдах зөвлөл байгуулна | Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны 05 сарын 31-ны өдрийн А/43 дугаар тоот тушаалаар Сонгон шалгаруулах хороог 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.<br>Олон нийтийн төлөөллийг сонгон шалгаруулах зарыг цахим хаягуудад 3 удаагийн давтамжтай байршуулсан.<br>АШУИС-ийн багш нар орон нутагт ирж, Азийн хөгжлийн банкны санхүүжилттэйгээр хэрэгжиж буй “Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг сайжруулах” төслийн хүрээнд “Стратегийн худалдан авалт ба эмнэлгийн санхүүжилтийн удирдлага”, “Аймгийн Нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл” сэдэвт сургалтыг 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулж, холбогдох байгууллагуудын удирдлага, албан тушаалтнуудаас бүрдсэн 40 хүнийг хамруулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Сургалтын тоо 2, хамрагдсан хүний тоо 55<br>Төлөөлөн удирдах зөвлөлийн олон нийтийн төлөөллийг сонгон шалгаруулалах зарыг цахим хаягуудад 3 удаагийн давтамжтай байршуулсан. | 90.0 | |
| **Бодлогын зорилгын дундаж үнэлгээ** | | | | | | | | | **89.7** | |

**2022 ОНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО**

| № | Бодлогын зорилтын нэр | Салбарын зорилт | Арга хэмжээний тоо | Дундаж үнэлгээний хувь |
|---|---|---|---|---|
| 1 | **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ** Зорилго 2. Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн орчныг бүрдүүлнэ | **Зорилго 2.2.** Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, эмнэлгийн мэргэжилтний хангалтыг сайжруулж, чадавхыг дээшлүүлнэ | 8 | 89.7 |
| | **Бодлогын зорилтын дундаж үнэлгээ** | | **8** | |
| **ДҮГНЭЛТ** | | | **8** | **89.7** |

ТАЙЛАН ХЯНАСАН: ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА Ц.МӨНХ-ОД

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.БАЯРМАА